

**“ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТ**
(2018 оны жилийн эцсийн байдлаар)

2019.01.30

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл											
1	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр. 2016.05.22 №233	Хөтөлбөрийн зорилго: Монгол Улсын иргэн бүрийн эрх ашгийг хэрэглэгчийнх нь хувьд хамгаалахад шаардлагатай эрх зүйн орчин, оновчтой тогтолцоо бүрдүүлэх, зах зээлд бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэгчийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн ухаалаг хэрэглээг төлөвшүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.											
2	Санхүүжилтийн эх үүсвэр	-улсын болон орон нутгийн төсөв; -төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж; -олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;											
3	Монгол Улсын Засгийн газар, Шадар сайд /2016-2020 он/	<u>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага:</u> Монгол Улсын Засгийн газар, Шадар сайд, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар <u>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:</u> Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар											
4	Хөтөлбөрийн зорилтууд	Зорилт:1.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох; Зорилт:2.Хэрэглэгчийг соён гэгээрүүлэх, мэдлэг, боловсрол олгох; Зорилт:3.Хэрэглэгчид хүрч байгаа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний стандарт, чанар, аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх; Зорилт:4.Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад олон нийт, бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх.											
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)											
		Үүнд	Төсөв			Гүйцэтгэл			Хувь				
		Багц 1	-	-	-	-	-	-	-	-	-	-	
		Багц 2	-	-	-	-	-	-	-	-	-	-	
	Хөтөлбөрийн зорилт	Биелэлт											
6	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: 5.1.1. хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин боловсронгуй болсон байна;	3.1.2. Орон нутагт Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд аймаг болон сумдын Засаг даргын захирамжаар “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах аймаг, сумын орон тооны бус зөвлөл байгуулагдаж, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын тушаалаар аймагт орон тооны											

<p>5.1.2. холбогдох стандарт, хэм хэмжээ, бусад зохицуулалтын актууд батлагдсан байна;</p>	<p>бус улсын 3 байцаагчийг ажиллуулж байна. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хэрэглэгчийг мэдээ, мэдээллээр хангах зорилго бүхий “Хэрэглэгчийн төв” байгуулах зорилтыг дэвшүүлэн, зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Аймгийн Засаг даргаас сумдын Засаг даргатай байгуулсан гэрээнд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар тодорхой заалтуудыг тусгаж, арга зүйн заавар зөвлөмж, мэдээ, мэдээллээр ханган, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>3.1.5. Аймгийн Засаг даргын Тамгын газраас иргэний нийгмийн байгууллагуудын гишүүдийг сургалтанд хамруулах, туршлага судлуулах, чадавхижуулах, ажиллах орчин нөхцлөөр хангах зэргээр бодлого зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг авч, дэмжлэг үзүүлэн, байнгын хамтын ажиллагаатай ажиллаж байна. Аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 25 төрийн бус байгууллагууд нэгдсэн Иргэний нийгмийн байгууллагуудын холбоо байгуулагдан нэгдмэл зохион байгуулалтад орж, аймгийн Засаг даргын Тамгын газраас “Нутгийн удирдлагын II байр”-нд өрөө тасалгаагаар ханган, “Ноёд” худалдааны төвд сургалтын танхимыг шинээр ашиглалтад оруулж, төрийн бус байгууллагуудын гишүүдийг чадавхижуулах сургалтуудад тогтмол хамруулан, төр, төрийн бус байгууллагын түншлэлийг өргөн хүрээнд хэрэгжүүлэн сургалт, сурталчилгаа, бодлого нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран аймгийн төвд зохион байгуулсан уулзалт, сургалтад Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг болон бусад төрийн бус байгууллагуудын төлөөллийг хамруулж, арга зүйн заавар, зөвлөгөөг өгч ажиллалаа. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2018.07.09-ний өдрийн “Чиглэл өгөх тухай” 1/984 дүгээр албан тоотын хэрэгжилтийг хангаж, аймгийн Засаг даргын 2018.07.30-ны өдрийн “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах ажлыг эрчимжүүлэх, зөвлөгөөн зохион байгуулах тухай” А/293 тоотыг захирамжийг гаргаж, сумдад хэрэглэгчийн эрхийг хамгаалах сумын зөвлөгөөнийг зохион байгуулж ажиллалаа. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах аймгийн орон тооны бус зөвлөлийг хуралдуулж, тус зөвлөлөөс авч хэрэгжүүлсэн 2018 онд хийж хэрэгжүүлсэн болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлж, сумдад хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хүргүүлж, арга зүйн заавар зөвлөмжийг өгч ажилласан. Зөвлөлийн хурлаар зөвлөлийн гишүүдэд сумдыг хуваарилах ажлыг зохион байгуулж, гишүүд хариуцсан сумдтайгаа хамтран ажиллах, харилцан туршлага судлах боломж нөхцлийг бүрдүүлж, үүрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>3.1.8. Аймгийн хэмжээнд одоогийн байдлаар хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллага болох “Хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах нийгэмлэг”-ийн салбар үйл ажиллагаагаа явуулж байна. Тус байгууллагын үйл ажиллагааг дэмжин байрны асуудлыг шийдвэрлэж Нутгийн захиргааны 3-р байранд өрөө тасалгаагаар ханган, ажиллах орчин нөхцлийг бүрдүүлсэн.</p>
--	---

<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: 5.1.3. хэрэглэгч өөрийгөө болон гэр бүлээ аливаа эрсдэлээс хамгаалах мэдлэг, хэрэглээний соёлтой болсон байна; 5.1.4. хэрэглэгчийг тогтмол зөвлөгөө, зөвлөмжөөр хангах тогтолцоо бүрдсэн байна; 5.1.5. хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хүний нөөцийн болон санхүүгийн чадавх сайжирсан байна;</p>	<p>3.2.1. Худалдааны газрууд нь худалдан авагчийн буланд дэлгүүрийн танилцуулга, хүнсний бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээний бичиг баримт, ариутгал, цэвэрлэгээг хийх санамжийг байрлуулж тавьсан эсэхэд байнгын хяналт тавин ажиллаж байна. Мөн хүнсний дэлгүүр, нийтийн хоол үйлдвэрлэлийн газрууд нь Худалдааны газрын стандарт MNS 5021-2007, Хоолны газрын стандарт MNS 4946-2005 стандартуудыг 80 хувь ханган ажиллаж байна.Нийтийн хоол үйлдвэрлэлийн газар, зочид буудлуудад Нийтийн хоолны стандарт MNS 4946-2005, Зочид буудал MNS 4588-2008 стандарт, “Хүнсний аюулгүй байдлын тухай”, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн” тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, “Гурван-Мэргэд” хүнсний зах, Олон улсын худалдааны төвд хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтийг хамарсан хоол хүнсээр дамжих өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, худалдан борлуулж байгаа бараа бүтээгдэхүүн түүний хадгалалт, тээвэрлэлтийн горим, бүтээгдэхүүний аюулгүй байдлын баталгаажуулалтын байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, биелэлтийг хангуулах болон тэдгээрийн хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх зорилгоор бодлогын түвшинд хяналт тавьж ажиллалаа.</p> <p>3.2.2. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн үүрэг, чиглэл, зөвлөмжийн дагуу Өрсөлдөөний тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн талаарх танилцуулга, сургалт болон Монголын Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооноос зохион байгуулсан болон Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс зохион байгуулсан сургалтуудад аймгийн “Хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах нийгэмлэг”-ийн тэргүүн болон зарим төрийн бус байгууллагын төлөөллийг тус тус хамруулж мэргэшүүлэх, чадавхижуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн ШӨХТГ, “Жайка” олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад орон тооны бус улсын ахлах байцаагч Д.Ёндонжамц, Хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн Д.Уранчимэг, Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Д.Ган-Отгон нар хамрагдсан.</p> <p>3.2.3.“Хэрэглэгчийн эрх” аян, “Хэрэглэгчээ сонсьё” сэдэвт өдөрлөгийг аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс, зарим сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж ажиллалаа. Тухайлбал Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, хэрэглэгчид хэрэглээний соёл эзэмшүүлэх, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль”, “Өрсөлдөөний тухай хууль”, “Зар сурталчилгааны тухай хууль”-ийг сурталчлан таниулах сургалтыг Баруунбүрэн сумын 16 аж ахуйн нэгж, Баянгол сумын 134 төрийн албан хаагч, иргэд, худалдаа үйлчилгээ эрхлэгч 46 иргэнд, Сүхбаатар сумын 12 аж ахуйн нэгжийн 64 ажилтан 18 иргэнд,</p>
---	--

Шаамар сумын 7 аж ахуйн нэгжид болон Орхон сумын 11 аж ахуйн нэгж, 66 төрийн албан хаагч, 21 иргэнийг тус тус хамруулан зохион байгуулж, хэрэглэгчийн эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг олголоо. Эрүүл мэнд, боловсрол, хүнс, хөдөө аж ахуйн хяналтын чиглэлээр 20 сургалт, Байгаль орчин, геологи уул уурхай, дэд бүтэц, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр 6 сургалт тус тус зохион байгуулж сургалтанд нийт 291 аж, ахуйн нэгж, байгууллагын 495 иргэд, албан хаагчдыг хамрууллаа. Хэрэглэгчдэд хэрэглээний боловсрол олгох, хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Аймгийн Засаг даргын А/293 дугаар захирамжийн хүрээнд сумдууд анхдугаар зөвлөгөөнөө амжилттай зохион байгуулж, тухайлбал Ерөө сумын аж ахуйн нэгж, худалдаа эрхлэгч болон иргэд тулгамдаж буй асуудлуудаа харилцан ярилцаж, ойлголцсоны үндсэн дээр цаашид дагаж мөрдөх 5Х зөвлөмжийг гаргасан байна. Үүнд:

- 1.Хэрэглээний соёлд иргэн бүр суралцъя
- 2.Хэрэглэгчийн эрхийг хүндэтгэн түргэн шуурхай, соёлтой үйлчилье
- 3.Хууль тогтоомж, стандартыг сахин биелүүлье
- 4.Хувийн эрх ашгийг бус нийтийн эрх ашгийг хүндэтгэе
- 5.Харилцан ойлголцож хамтран ажиллая

3.2.4.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах аймгийн орон тооны бус зөвлөлөөс санаачлан 2017 онд Стандарт, хэмжил зүйн хэлтэс болон зарим сумдын ЗДТГ-тай хамтран худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд стандарт, баталгаажуулалт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар мэдлэг олгох, мэдээлэл хүргэх зорилгоор Хүнсний аюулгүй байдал, стандартчиллын өнөөгийн байдлын тухай”, “Хэмжил зүйн баталгаажуулалтын талаар”, “Зураасан код хэрхэн ашиглах тухай” сэдвүүдээр сургалт, мэдээллийн арга хэмжээг, Цагааннуур суманд сумын Худалдаа үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоотой хамтран худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн дунд “Стандарт-худалдаа, үйлчилгээнд” сэдэвт ажил мэргэжлийн уралдааныг, 2018 онд Стандарт, хэмжил зүйн хэлтэс, “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ, “Урсгал Ус” ХХК, “Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-тай хамтран “Хэрэглэгчээ сонсьё” өдөрлөг, бүх сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад “Хүүхэд бүрийг хэрэглээний соёлд суралцуулъя” сургалтыг тус тус зохион байгууллаа.

3.2.5.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, иргэдийн санал өргөдөл, гомдлыг хүлээн авах зорилго бүхий 7036-2259 дугаарын утсыг шинээр ашиглалтад оруулснаас гадна аймгийн Засаг даргын Тамгын газрын 7036-1111 утсаар иргэдийн санал өргөдөл гомдлыг хүлээн авч байна. Иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, хэрэглэгчийн боловсрол олгох болон санал хүсэлтийг хүлээн авах “Сэлэнгэ аймаг, Хэрэглэгчийн эрх” фэйсбүүк хуудсыг шинээр ашиглалтад оруулан ажиллаж байна.

3.2.6.Бизнес эрхлэгчийн зүгээс хүнсний бүтээгдэхүүн

		<p>үйлдвэрлэгчээс хэрэглэгчийн гар дээрх хүрэх бүх үйл явцын талаарх мэдээллийг хэрэглэгчдэд нээлттэй болгох ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Энэ ажлын эхлэл болгож 179 ахуйн нэгжийн 133 худалдаа үйлчилгээний газар, хүнсний дэлгүүр, мухлаг, минимаркетын худалдаалж буй бүтээгдэхүүнд “Савласан хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүн”-тэй нийцэж буй эсэхэд байнгын хяналт тавин ажиллаж байна.</p> <p>3.2.7.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий салбар зөвлөлүүдийг сумдад аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэрийн газар, төрийн болон төрийн бус байгууллага, багийн Засаг дарга, иргэдийн төлөөллийг оролцуулан 30-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр 17 суманд сумын Засаг даргын орлогч, ЗДТГ-ын даргаар ахлуулан байгуулж үйл ажиллагааг эхлүүлсэн. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах аймгийн болон сумын орон тооны бус зөвлөлүүд хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр Шударга өрсөлдөөн, Хэрэглэгчийн төлөө газраас мэргэжил арга зүйн заавар зөвлөмж, зөвлөгөө дэмжлэгийг тухай бүр авч ажиллаж байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг 2018 оны 01 сарын 23-ны өдөр Монгол Улсын Шадар сайдын дэргэдэх “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих зөвлөлийн хоёрдугаар хуралдаанаар хэлэлцүүлж, арга зүйн заавар зөвлөмжийг авч ажилласан.</p> <p>3.2.8.Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, аймгийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс бүх сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Боловсрол, соёл урлагийн газар болон Ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран 2018 оны 3 сард БСШУСЯ-аас бэлтгэсэн хичээлийн хүрээнд нийт сумдын Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад хэрэглэгчийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан. Мөн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн гишүүд оролцон аймгийн төв Сүхбаатар сумынерөнхий боловсролын 7 сургуулийн ахлах ангийн 313 сурагчдыг “Хүүхэд бүрийг хэрэглээний соёлд суралцуулъя” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.</p>
3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн : 5.1.6. бизнесийн байгууллагууд хэрэглэгчид хандсан менежментийн чиг хандлагыг тэргүүлэх чиглэлээ болгосон байна; 5.1.7. хэрэглэгчийн		<p>3.3.1.Аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлтэй хамтран аймагт үйл ажиллагаа явуулж буй эрчим хүч, дулаанаар үйлчилдэг 19 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн дулааны үнэ тарифын судалгаа, аймгийн төв болон сумдад үйл ажиллагаа явуулж буй Шатахуун түгээх салбар, станцууд, даатгалтай эмийн бөөний болон жижиглэн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн, худалдааны төв, захуудын, сууц өмчлөгчдийн холбоодын судалгааг тус тус гаргаж ажиллалаа. 2017 онд 53 хуулийн этгээд, аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, 723 зөрчил илрүүлж, 188 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 2 аж ахуй нэгжийн үйл ажиллагааг түр зогсоож, улсын байцаагчийн 4 заалт бүхий 18 албан шаардлага, 44 дүгнэлт, 6 зөвлөмжийг тус тусгч,</p>

	<p>эрхийг хамгаалах оновчтой тогтолцоо бий болсон байна;</p>	<p>1 иргэнд 240.000 төгрөгийн торгуульногдуулж ажиллалаа. 2018 оны 7 сарын байдлаар 151 хуулийн этгээд хяналт шалгалтад хамрагдаж, 1257 зөрчил илрүүлж, 392 зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 19-ний “Хэрэглэгчийн хяналтын хуудсыг батлах тухай” А/114 тоот тушаалын хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газар Хэрэглэгчийн хяналтын хуудсыг сурталчлах, мэдээлэх, зөвлөгөө өгөх ажлыг аймгийн хэмжээнд нийт 640 иргэн, 280 гаруй аж ахуйн нэгж, байгууллагад сурталчилж, 500 гаруй гарын авлага, зөвлөмжийг тараан ажиллалаа.</p> <p>3.3.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс чанарын удирдлагын тогтолцоонд шилжиж, Алтанбулаг, Орхонтуул сум чанарын удирдлагын тогтолцоонд шилжихээр ажиллаж байна. Дээрх байгууллагууд болон Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Үйлдвэрчний эвлэлийн холбоодын удирдлага, ажилтнууд, аймаг дахь орон тооны бус 3 улсын байцаагчдыг чадавхижуулах сургалтуудад тухай бүр хамруулж, мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Орон тооны бус Улсын ахлах байцаагч Д.Ёндонжамц Жайка олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтанд хамрагдсан.</p>
	<p>4-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: 5.1.8. хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо нэмэгдэж голлох үүрэгтэй болсон байна.</p>	<p>3.4.1. Хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлсэн үйл ажиллагаа явуулдаг нийгмийн хариуцлагатай аж ахуй эрхлэгчдийг дэмжин ажиллаж байна.</p> <p>3.4.2. Аймагт хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүргийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн газрын орон тооны бус 3 улсын байцаагч болон аймаг, сумдад Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлүүд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Энэ ажлын хүрээнд 2017 онд аймгийн албан ёсны www.selenge.gov.mn цахим хуудсанд “Хэрэглэгчийн эрх” цэс болон 7036-2259 дугаарын утсыг шинээр, 2018 онд аймаг, сумдын зөвлөлүүд харилцан мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа мэдээлэх, хэрэглэгчдэд мэдлэг олгох зорилго бүхий “Сэлэнгэ аймаг, Хэрэглэгчийн эрх” фэйсбүүк хуудас болон selenge.afccp2018@gmail.com цахим шууданг тус тус ашиглалтад оруулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>3.4.4. Сэлэнгэ аймгийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулж, сургалт, сурталчилгааны зарим ажлуудыг гүйцэтгүүлж байна. Аймгийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлд дээрх байгууллагуудын төлөөллийг оруулж, жил бүрийн төлөвлөгөөнд хариуцаж хэрэгжүүлэх ажлуудыг тусган хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх, хяналт шалгалтын ажлыг жил бүр хамтран зохион байгуулж байна.</p>
7	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах</p>	<p>Хөтөлбөр хэрэгжсэнээр хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин боловсронгуй болох, хүний нөөцийг чадавхижуулах,</p>

	асуудлууд)	хэрэглэгчийг соён гэгээрүүлэх, мэдлэг боловсрол олгох ажлыг тодорхой болгож, ажил хэрэг болгохоор зорьж, аймаг, сумдад Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөлүүд байгуулагдаж, орон тооны бус улсын байцаагчдын тоо нэмэгдсэн зэрэг эерэг ололттой талууд байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар шийдвэрлэж, орон нутагт хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн байгууллагын бүтэц, нэгжийг бий болгож, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч, идэвх санаачлагатай ажиллах. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2018.07.09-ний өдрийн “Чиглэл өгөх тухай” 1/984 дүгээр албан тоотой өгсөн чиглэлийн хүрээнд аймгийн Засаг даргын 2018.07.30-ны өдрийн А/293 тоотыг захирамжаар сум бүр Хэрэглэгчийн эрхийг хамгаалах анхдугаар зөвлөгөөнөө зохион байгуулсан нь үр дүнтэй ажил болсон.					
8	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Аймаг, сумын Засаг даргын захирамжаар “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл”-үүд аймаг, сумдад байгуулагдсан боловч хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө, санхүүгийн асуудал сумдад шийдвэрлэгдээгүй байна. Хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах нийгэмлэгийн хүний нөөцийг нэмэгдүүлж чадавхижуулах шаардлагатай байна.					
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт2	Зорилт3	Зорилт 4
		85 %	4	70 %	100 %	100 %	70 %

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС